

## Монгол улсын хүн амын өсөлтөд гарч буй хүн ам зүйн хямрал

*Ц. Цэдэв*

*Иргэний Бүртгэл Мэдээллийн*

*Улсын Төвийн хэлтсийн дарга*

*Дэд. док*

Аливаа улсын хүн амын тоо болон чанарын асуудлыг судлан үзэхдээ гол асуудлын нэг болох насны бүтцэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байдаг. Статистикийн урьдчилсан гүйцэтгэлээс үзэхэд 1997 онд Монгол улсын хүн ам 2 сая 387.1 мянга болж, өнгөрсөн оныхоос 1.4 хувиар өсчээ. Гэтэл 1956 оны хүн амын тооллогоор 2 сая 43.9 мянга болж, энэ хоёр тооллогын хоорондох 33 жилд хүн ам 2.45 дахин өссөн байна.

Хүн амыг насны бүтцээр судлан үзэхэд 1956 оны тооллогоор 0–9 насны хүүхэд 195.5 мянга байсан бол 1979 онд 498.5 мянга буюу 1.2 дахин, 1989 онд 600.0 мянга буюу 1956 оныхоос 3.1 дахин тус тус нэмэгджээ. Нийт хүн амын дотор 0–9 насны хүүхдийн эзлэх хувийн жин 1956 онд 23.2, 1989 онд 30 хувиас давуу болсон байна. Нийт хүн амын дотор 0–9 насны хүүхдийн эзлэх хувийн жин ийнхүү өндөр байгаа нь түр зуурын хугацаанд нийгэм эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг талтай. Тухайлбал, 0–9 насны хүүхдийн амьдрал ахуйд үзүүлэх нийгэм, эдийн засгийн үйлчилгээ, тусламж нь нийгмийн бүх үйлчилгээний дотор зонхилох байр эзэлж, улс ардын аж ахуйд ажиллагчдын нийт хүн амд эзлэх хувийн жинг багасган, тэдгээрт ногдох эдийн засгийн ачааллыг нэмэгдүүлдэг байна. Материаллаг бус үйлдвэрлэлийн хүрээ, ялангуяа эмнэлэг, боловсрол гэх мэт үйлчилгээний хүрээний ажиллагааг нэмэгдүүлж, зардлыг өсгөнө. Гэхдээ чухамхүү 0–9 насны хүүхдийн нийт хүн амд ногдох хувийн жин өндөр байж сая үндэсний удам угсаа сайжирч, хүн ам өсөн нэмэгдэх эрүүл саруул нөхцөл бүрдэн потенциал чанар нь сайжирч төлөвшдөг учиртай. 0–9 насны хүүхдийн насны бүтэц, жил бүр тэдгээрийн нас бүрт болох насны дэвшилтээс 10–19 насны өсвөр үеийн бүтэц төлөвшинө. Энэ бүхнээс үндэслэн 1959–1989 онуудад манай улсын нийт хүн ам өсөн нэмэгдэх эрүүл үндэс суурь буй болсон нь Монгол улсын үндэсний хөгжлийн асар том амжилт ололт мөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

1956 онд 10–19 насны өсвөр үеийнхний тоо 69.8 мянга байсан бол 1989 онд 241.3 мянга буюу өнгөрсөн дээрх хоёр тооллогын хоорондох 33 жилд 3.5 дахин нэмэгджээ. 0–19 насны хүн амын өсөлтийн хэмжээ энэ түвшиндээ хадгалагдаж байсан бол Монгол хүний удам угсаа нөхөн төлжих хэвийн үйл явцыг адаглаад 50–аас доошгүй жил үргэлжлүүлэх шаардлагатай байжээ. Энэ нь Монгол үндэстний нөхөн үржихүйн үйл явцад тохиолдсон томоохон гажуудал болсон гэж үзэж болох талтай билээ.

Аливаа нэг үндэстэн, хүн амын хөгжлийн байдлыг жилийн дундаж өсөлт ерөнхийд нь тодорхойлдог. Манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 1940–өөд оны хоёрдугаар хагаст 1.50–2.00 хувь, 1956–1963 онд 2.70 хувь, 1963–1969 онд 2.75 хувь 1969–1979 онд 3.25 хувь, 1979–1989 онд 2.80 хувь тус



хувьд төрөлт өндөр, хүүхдийн нас баралт ч өндөр байсан 1990 оны эхэн үед үр хөндөлтийг чөлөөтэй болгох хууль гарган түүнээс хойш жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг чөлөөтэй сурталчилж, түгээмлээр хэрэглэж эхэлсэн, өнөөгийн зах зээлийн шилжилтийн үед өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өсч, ядуурал ихсэж байгаа гэх мэтчилэн олон шалтгаанаас хамааран монгол улсын хүн ам зүйн хямрал эхлэх эх суурь тавигдаж, цаашид улам гүнзгийрэх чиг хандлагатай боллоо. Иймээс хүн ам зүйн шинжлэх ухаанд бодитой ул суурьтай хандан 1996 онд баталсан Монгол улсын хүн амын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар илүү анхаарах цаг болжээ.

Монгол улсын хүн амын жилийн цэвэр өсөлтийг авч үзэхэд, 1940 онд 3.1 мянган хүн байсан бол энэ тоо жил бүр байнга өссөөр 1988 онд хамгийн оргил үед буюу 58.1 мянга болж, 1990 оноос эхлэн буурч, 1993 онд 30.3 мянга буюу бараг 2 дахин буурсан байна. Монгол улсын хүн амын талаар төрөөс баримтлах бодлогод 2005–2015 он хүртэлх хугацаанд хүн амын дундаж өсөлтийг 1.8 хувиас доошгүй түвшинд хадгалах зорилт дэвшүүлсэн. Мөн эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн дээр төрөлтийг зохистой зохицуулж, хүн амын өсөлтийг хангах тухай тодорхой заалтууд хамарсан билээ. Хүн амын бодлогод хоол хүнс, орон сууцны хангамж, боловсрол, ажил эрхлэлт, хүн амын шилжих хөдөлгөөн, гэр бүл зэрэг харилцан уялдаа бүхий цогц асуудлыг авч үзэхдээ хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настны хувьд илүү анхаарал хандуулсан байдаг. Гэхдээ Монгол улсын хүн амын жилийн дундаж өсөлт 1996 онд 1.5 хувь болон буурч, 1997 онд 1.4 хувь болон улам ч буурах төлөвтэй байгаа нь үнэхээр сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна. Бидний хийсэн судалгаагаар 2020 он хүртэл хугацаанд Монгол улсын хүн амын өсөлтийн төлөвийг дараах байдлаар харуулж болох юм.

#### Монгол улсын хүн амын өсөлтийн төлөв

Он	Өсөлт%	Он	Өсөлт%	Он	Өсөлт%	Он	Өсөлт%
1999	1.88	2005	2.18	2011	1.94	2017	1.67
2000	1.93	2006	2.14	2012	1.89	2018	1.63
2001	1.98	2007	2.14	2013	1.83	2019	1.60
2002	2.03	2008	2.14	2014	1.78		
2003	2.08	2009	2.02	2015	1.76		
2004	2.16	2010	2.00	2016	1.72		

Эндээс үзэхэд 1989 оноос 2020 хүртэл манай улсын хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдац даруй 2 дахин хорогджээ. 1990– ээд оны эхний 1–р хагаст уул өсөлтийн хурдац наяд оны хоёрдугаар хагасийн хурдацаас 2 дахин буурсан байна. Хүн амын өсөлтийн хурдац ингэж буурч байсан үзэгдэл түүхэнд ховор гарч байсан үзэгдэл юм. Тухайлбал Хятад улс 1960–1975 оны үед олон сая идэр эрэгтэйчүүдийн үрийн хоолойг боож, төрөх насны эмэгтэйчүүдэд бараг нийтэд нь ерөндөг тавих, ЖУС эмийг хэрэглэж жирэмслэлтээс сэргийлэх, айл өрх бүр нэгээс дээшгүй хүүхэдтэй байх зэрэг хатуу бодлого явуулсны үр дүнд ийм үзэгдэл гарч байсан удаатай.



Хүн амын өсөлтөд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл нь нялхсын нас баралт байдаг. Манай улсад хүүхдийн, ялангуяа нялхсын нас баралт тууштай буурсаар байгаа нь өндөр ач холбогдолтой юм. Бидний хийсэн судалгааны үр дүнд хүүхдийн нас баралтын тоо буурсан магадлалыг дараах хүснэгтээр харуулав.

**Монгол улсын хүүхдийн нас баралт буурсан магадлал**

Нас	1955-1956	1962-1963	1968-1969	1978-1988	1988-1989
0	0,10099	0,08572	0,07470	0,04908	0,04492
1	0,02526	0,01995	0,01805	0,01482	0,01440
2	0,01289	0,01039	0,01126	0,00784	0,00730
3	0,00904	0,00616	0,00044	0,00443	0,00549
4	0,00599	0,00516	0,00403	0,00309	0,00369
5	0,01530	0,01142	0,01002	0,00911	0,00877
10-14	0,01370	0,01024	0,00801	0,00401	0,00680

1955-1956 онд амьд төрсөн нийт 100000 хүүхдийн 10099 нь 1 хүртэлх насандаа нас барах магадлалтай, 1968-1969 онд тэрхүү магадлал нь 7470, харин 1988-1989 онд 6692 болж буурчээ. Хоёр насанд бол энэ төрсөн хүүхдийн 1289, 1126 ба 730 нь тус тус нас барах магадлалтай байжээ. Дөрвөн насанд уул магадлал 599, 403, 369 болон буурсан байна.

5-9 насанд 100000 үе чацуутнаас 1530, 1052 ба 897 нь, 10-14 насанд 1370, 801 ба 680 нь тус тус нас барах магадлалтай байна. Төрөлтийн түвшинд гарсан хэлбэлзэл мөн түүнчлэн нас баралтын бүтцэд гарсан өөрчлөлт нь хүн амын насны бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлтийг оруулжээ. Хүүхдийн нас баралт буурахад хүний тоо зайлшгүй нэмэгдэх нь зүйн хэрэг.

1956 оноос 1989 он хүртэл манай улсын хүн амын дундаж наслалт 55.65 наснаас 63.41 нас хүртэл буюу 7.46 жилээр нэмэгдсэнд түлхүү нөлөөлсөн хүчин зүйл нь дээрх хүснэгтэд харуулсан хүүхдийн нас баралт багассаны үр дүн гэж үзэж байна. Үүнд мэдээжээр нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлсөн нь мэдээж. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 55.06 наснаас 62.49 нас хүртэл буюу 7.73 жилээр, эмэгтэйчүүдийн 56.49 наснаас 64.06 нас хүртэл буюу 7.34 жилээр нэмэгджээ. Дундаж нас нэмэгдсэн шалтгааныг судлан үзэхэд эрэгтэйчүүдийн дундаж наслалтын үзүүлэлтийн 83 хувь нь 0-1 насны хүүхдийн, 5.5хувь нь 1-15 насан дахь хүүхдийн нас баралт буурсны үр дүнд, эмэгтэйчүүдийнх 76 хувь нь 15 хүртэл насанд, 24 хувь нь 15-аас дээш насанд (23.4 хувь нь 15-60 насанд, 60 ба дээш насанд) нас баралт буурснаас нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл залуу насанд нас баралтын бууралт их хэмжээтэй байснаас дундаж наслалтын хэмжээг нэмэгдүүжээ. Насны бүтцэд гарсан ийм өөрчлөлт нь хүн амын доторх хижээл настны хувийн жинг нэмэгдүүлж чаддаггүй байна.

Хүн амын дотоод бүтцээс урган гарсан, түүний мөн чанарыг илэрхийлэгч болох өсөлтийн хурдацийн явц нь хүн амын чанарыг тодорхойлогч нь байдаг. Хүн амын баттай бөгөөд ирээдүйн хөгжлийн анхдагч



болох чанар нь хүн амын тогтонги бүтэц юм. Тогтонги бүтэц нь зохиомлоор тогтон төлөвшдөггүй, нийгэм-эдийн засгийн, нийгэм-биологийн хүчин зүйн цогцолбор нөлөөн доор тогтдог байна. Бидний судалгаагаар хүн амын бүрэлдэн тогтсон өсөлтийн явц, тухайлбал 2020 оны орчим тэрхүү тогтонги бүтэц бий болох байжээ.

Гэвч Монгол улсад гарсан хүн ам зүйн хямралаас шалтгаалан манай улсын хүн амын тогтонги бүтэц нь манай бидний тооцоолсон 2020 оны орчимд болохгүй доор гэхэд 20-оос дээш жилээр хойшилжээ гэж үзэж байна. Үүнээс болж ямар сөрөг асуудал гарч болох вэ гэвэл, нэгдүгээрт хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдац тууштай буурах хандлагад орж байна. 1998 оноос Төр засаг нийгэм-эдийн засгийн цогцолбор арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлж чадах аваас аяндаа хүн амын өсөлтийн хурдац нэмэгдсээр 2014 он хүртэл үргэлжлэх хандлагатай байгаа бөгөөд 2015 оноос хүн амын өсөлт багасах хандлагатай болж улмаар төрөх насны эмэгтэйчүүдийн тоо хорогдон төрөлт хоёрдахь удаагаа буурах хандлагад зайлшгүй орно. Хүн амын өсөлт цаашид ямар байдлаар үргэлжлэх нь маш эргэлзээтэй байна. Хоёрдугаарт, хүн амын хөгшрөлт 60 ба түүнээс дээш насанд эхэлдэг зүй тогтолтой байсан бол хүн ам зүйн хямралаас болж 40-өөд насанд шилжиж, тэднээс манайд учрах анхны хөгшрөлтийн аюул эхлэх болно. Түүнээс сэргийлэхийн тулд төрөлтийг аль болох тууштай нэмэгдүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй юм.

Манай улсын хүн амын дунд нас арифметикийн жигнэсэн дунджаар 1956 онд 28.8 жил байсан бол 1963, 1969, 1979, 1989 онуудад 27.0, 25.5, 24.0, 23.5 жил болж залуужсан байна. Хүн амын медиан нас буюу нийт хүн ам дээрх онуудад 24, 23, 18, 17, 18 насуудад яг тэнцүү хоёр хэсэг хуваагдаж байжээ. Энэ хоёр үзүүлэлт нь манай улсын хүн ам богино хугацаанд насны хувьд эрс залуужсаны баталгаа юм. Гэтэл хүн ам зүйн хямралаас болж 1999, 2009, 2019 онд дунд нас нь арифметикийн жигнэсэн дундаж хэмжигдэхүүнээр 25.9, 27.3, 28.9 жил, медиан дундажаар 21, 23, 26 нас болж нэмэгдэх тооцоо гарч байна. Энэ бол өвөрмөц хэлбэрийн хөгшрөлт болохын баталгаа билээ. Хүн ам зүйн хямралаас шалтгаалан цаашид хүн амынхаа өсөлтийн хурдацийг жил тутам 2 хувь болгож чадсан гэсэн ч 2020 онд нийт хүн ам потенциал хүн амын тооноос хамгийн доод хэмжээгээр 300 мянган хүнээр дутуу байх төлөвтэй байна.

Иймд хүн амын талаар Төрөөс баримтлах бодлогын дагуу хүн амын өсөлтийн жилийн өсөлтийг 1.8 хувиас дээш түвшинд ойртуулах нийгэм-эдийн засгийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь зүй ёсоор тавигдаж байна.